

Дэлхийн Банк

ҮНДЭСНИЙ ЦӨӨНХ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн дугаар №: P 173126

2020 оны 2-р сарын 26

Монгол:Тогтвортой амьжиргаа-3 Нэмэлт санхүүжилтийн төсөл



Бэлтгэсэн: Тогтворжтой амьжиргаа-3 төслийн нэгж

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих тус төлөвлөө нь Хүлээн авагчийн баримт бичиг юм. Энд дурьдсан саналууд нь ДБ-ийн Захирлуудын зөвлөл, Удирдлага, ажилтнуудын санаа бодлыг төлөөлөх шаардлаггүй бөгөөд урьдчилсан байдлаар илэрхийлсэн санал юм.

Товчлол болон товчилсон үг

ХНЗ	Хөтөлбөрт нийцүүлсэн зээл
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ
АДБ	Аймгийн дэмжих баг
НС	Нэмэлт санхүүжилт
ТА-3	Тогвортой амьжиргаа-3 төсөл
ГШМ	Гомдол шийдвэрлэх механизм
ХШҮ	Хяналт шинжилгээ, үнэлгээ
ТОНА	Төслийн орон нутгийн ажилтан
УМС	Удирдлагын мэдээллийн систем
НТХ	Нэгдсэн төсвийн тухай хууль
ҮЦИОДТ	Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих төлөвлөгөө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОНУАТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
ТББ	Төрийн бус байгууллага
АД	Ажлын даалгавар
СЯ	Сангийн яам
ЗҮ	Зөвлөх үйлчилгээ
СУ	Санхүүгийн удирдлага
БОНҮ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
НӨҮ	Нөлөөллийн ерөнхий үнэлгээ

Агуулга

Хэсэг А. Төслийн тухай.....	4
Төслийн Хөгжлийн Зорилго	4
Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд	4
Бүрэлдэхүүн хэсэг1: Орон нутгийн засаглал, амьжиргааг дэмжих чадавх бий болгох	5
Бүрэлдэхүүн хэсэг 2: Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан дэмжих хөтөлбөр	5
Бүрэлдэхүүн хэсэг 3: Төслийн удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээ ..	6
Хэсэг Б. Бодлого ба хууль эрхзүйн шаардлага.....	6
Б.1 Газрын тухай хууль	6
В.2 Орон нутгийн засаг захиргаа	7
Б.3 Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн тухай хууль.....	8
В.4 Нийгмийн халамжийн тухай хууль (2005)	8
В.5 Үндэсний цөөнхийн талаархи бодлого.....	9
В.6 Уугуул иргэдийн талаарх Дэлхийн банкны Үйл ажиллагааны Бодлого (ВР/ОР 4.10)	9
Хэсэг С. Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих төлөвлөгөө	10
С.1 Танилцуулга.....	10
Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих төлөвлөгөөг Дэлхийн банкны ОР 4.10, “Уугуул иргэд”-д заасны дагуу Монгол Улсын тогтвортой амьжиргаа(ТАЗ) -ын 3 дугаар үе шатны нэмэлт санхүүжилтэд зориулан боловсруулаад байна.....	10
С.2 Монгол Улсын Үндэсний цөөнх иргэд	10
С.2.1 Цаатан ба ТА-3 төсөл	11
С.2.2 Казах ба ТА-3 төсөл	12
С.2.4 Цаатан иргэдийн оролцоог хангах арга хэмжээг төлөвлөх.....	13
С.2.5 Казак иргэдийн оролцоог хангах арга хэмжээг төлөвлөх	14
D. Гомдол барагдуулах механизм (GRM)	14
E. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба төсвийн нөөц	15
J. Мэдээлэл ил болгох	15
Хэсэг Е. Хэлэлцүүлэг уулзалт	16

Хэсэг А. Төслийн тухай

Тогтвортой амьжиргаа-3 (ТА-3) төсөл нь Тогтвортой амьжиргааг дэмжих Үндэсний хөтөлбөр (2002-2016)-ийн гуравдугаар шат юм. Тогтвортой амьжиргааны хөтөлбөрийг гурван үе шаттай Хөтөлбөрт нийцүүлсэн зээлийн санхүүжилтэр хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулж байсан бөгөөд энэ ойлголцлын хүрээнд Монгол улсын Засгийн газар болон Дэлхийн банкны удирдах зөвлөлөөр батлагдсан. Тогтвортой амьжиргаа төслийн Хөтөлбөрт нийцүүлсэн зээлийн үе шат бүрийн зорилго, үндсэн онцлогууд болон үргэлжлэх хугацааг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх үед тодорхойлсон бөгөөд хараахан шинэчлэгдээгүй болно.

Хүснэгт 1: “ 3 үе шат бүхий Хөтөлбөрт нийцсэн зээл (2002-2022) Тогтвортой амьжиргаа төслийн тухай		
Үе шат	Зорилт	Үндсэн онцлог
Тогтвортой амьжиргаа төсөл-1 2002 - 2007	Сонгогдсон бүс нутагт боловсруулсан, батлагдсан, баталгаатай амьжиргааны түвшинг дээшлүүлэх үр дүнтэй хандлага, байгууллагын чадавхыг бий болгох бөгөөд ингэснээр эдгээр стратегиудыг хөтөлбөрийн II үе шатанд ашиглах боломжтой болно.	Байгууллагын бүтэц, тогтолцоо, үйл явцыг олж тогтоох, туршилтаар хэрэгжүүлэх
Тогтвортой амьжиргаа төсөл-2 2007 - 2012	Монгол орны хөдөөгийн ард иргэдийн эмзэг байдлыг бууруулах байгууллагын бүтэц, тогтолцоог сайжруулах замаар амьжиргааны аюулгүй, тогтвортой байдлыг хангах	Үндэсний, аймгийн, сумын түвшинд байгууллагын бүтэц, тогтолцоог сайжруулах
Тогтвортой амьжиргаа төсөл-3 2015 – 2022	Хөдөөгийн иргэдийн эмзэг байдлыг бууруулах зорилгоор төслийн I, II үе шатанд ашигласан тохиромжтой бүтэц, тогтолцоог Монгол орны хэмжээнд бүхэлд нь бий болгох	Урт хугацаанд тогтвортой байдлыг хангах мэргэжлийн болон байгууллагын инновацийг нарийвчлан тохируулах
Тогтвортой амьжиргаа төсөл-3 Нэмэлт санхүүжилт 2020-2022	Санал болгож буй төслийн үйл ажиллагаа нь одоо хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үргэлжлэл байх	Санал болгож буй Нэмэлт санхүүжилт нь бүрэлдэхүүн хэсэг I болон 2 н хүрээнд тусгагдсан төслийн үйл ажиллагааг дэмжих

2002 онд Дэлхийн банк 3 үе шаттай Хөтөлбөрт зохицуулсан зээлийн эхний үе шатыг баталсан бөгөөд бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн менежмент, мал аж ахуйн даатгалыг агуулсан санхүүгийн хүртээмжийг гүнзгийрүүлэх зорилгоор бичил санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн саналаар бүтээн байгуулах дэд бүтэц, суурь үйлчилгээг хөгжүүлэх гэсэн 3 үйл ажиллагаанд анхаарлаа хандуулсан.

Төслийн Хөгжлийн Зорилго

Тогтвортой амьжиргаа-3 төсөл нь Хөдөө орон нутагт нэн чухал ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал, иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготой.

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд

Бүрэлдэхүүн хэсэг1: Орон нутгийн засаглал, амьжиргааг дэмжих чадавх бий болгох

Тус бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон орон нутгийн хөгжлийг дэмжих бүтэц, тогтолцоог цаашид боловсуулах, хэрэгжүүлэх орон нутгийн болон үндэсний түвшний чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Орон нутгийн түвшинд Улсын нэгдсэн төсвийн тухай хууль болон Сум хөтөлбөрийн хүрээнд засаглалын үүрэг хариуцлага, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд мэдэгдэхүйц өсөлтийг бий болгон үр дүнтэй удирдахад Сумын засаг захиргаа бэрхшээлтэй тулгарч байна.

Төсөл орон нутгийн удирдлага, олон нийтэд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дунд хугацааны төлөвлөлтөд олон нийтийн оролцоо, төсөв төлөвлөх, батлах түүнчлэн худалдан авалт, удирдлага, тайлагналт, хяналт шинжилгээ болон үнэлгээ, бэлчээрийн газрын төлөвлөлт болон удирдлага зэргийг агуулсан төсвийн гүйцэтгэл зэрэгтэй холбоотой сургалт, мэргэжлийн туслалцаа үзүүлэх юм. Сургалт, мэргэжлийн туслалцааг аймагт суурилсан Сумын дэмжих багаар дамжуулан хүргэнэ.

Эдгээр багуудад сургалтын хөтөлбөр, материал боловсруулах, сургагч нарт зориулсан сургалт зэрэгт дэмжлэг үзүүлэх Үндэсний мэргэжлийн зөвлөх үйлчилгээний баг мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. Энэ тогтолцоо нь аймгийн түвшний баг болон сумын удирдлага, иргэд хоорондоо ойр, байнгын холбоотой байх боломжийг бүрдүүлэх юм. Сумын дэмжих баг, мэргэжлийн туслалцаатай холбоотой үйл ажиллагааг Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагтай (SDC) хамтран санхүүжүүлнэ.

Үндэсний түвшинд төсөл, Сум хөтөлбөр хэрэгжүүлэх, Орон нутгийн хөгжлийн санг хөгжүүлэхтэй холбоотой эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан төвийн олон нийтийн засаг захиргааны байгууллагуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэн ажиллана.

Одоо ч туршилтын үе шатандаа байгаа Сум хөтөлбөрийн хувьд, хөтөлбөрийг боловсруулж, өргөжүүлэх зорилгоор Эдийн засгийн хөгжлийн яаманд мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллана. Үүнд Сум хөтөлбөрийн туршилтын үе шатыг үнэлэх, үүнийг өргөжүүлэхийн тулд хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамж, гарын авлага, дүрэм, журмыг боловсруулах мөн хөтөлбөрийн удирдлага, хяналт шинжилгээний үндэсний түвшний тогтолцоог бэхжүүлэх зэрэг багтаж болно.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан дэмжих хөтөлбөр

Component 2.1: Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт

Сайн засаглалд зориулсан урамшууллын тухайд, төсөл Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулж суманд Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нь төсөв төлөвлөх, батлах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналт, дотоод, гадаад хяналт түүнчлэн олон нийтийн хяналт бүхий санхүүгийн болон бодлогын төлөвлөлтөөс эхлээд бүхэл бүтэн төсвийн төлөвлөлтийн үйл явц дахь сайн засаглалыг хангах зорилготой юм.

Сумын болон түүнээс доош түвшинд улсын хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл нь төсөв боловсруулах үйл явцын чухал хэсэг байдаг. Иргэдийн оролцоо, сумын төсвийг

багийн иргэдийн тэргүүлэх чиглэл болон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл явц, үр дүнг иргэдийн сэтгэл ханамжтай уялдуулахад онцгой ач холбогдол өгөх болно. Сумын гүйцэтгэлийн хяналт шинжилгээний системд суурилсан бие даасан шинжээчид бүх сумдын гэрээнд тусгасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг жил бүр үнэлнэ. Зорилтдоо хүрсэн болон давуулан биелүүлсэн сумууд дараагийн санхүүгийн жилийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэд санхүүгийн дэмжлэг хэлбэрээр тодорхой хувь авна.

Одоогийн байдлаар энэхүү зардлыг өмнөх жилийн төсвийн хуваарилалтын дээд тал нь ойролцоогоор 25 орчим хувь байж болох санал дэвшүүлж байна. Гэвч төслийн хэрэгжилтийн явцад үүнийг дахин хянаж авч үзэх бөгөөд шаардлагатай бол өөрчлөлт оруулж болно.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангийн хувиарлалтын дагуу Төрийн сангаар дамжуулан олгоно.

Бүрэлдэхүүн хэсэг 2.2: Жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

Төсөл, сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хувиарлалтыг тодорхойлох зорилгоор сумын жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнүүдийг зохион байгуулна. Сумын гүйцэтгэлийн үнэлгээ болон зэрэглэлийг улс төрийн хувьд төвийг сахисан гуравдагч этгээд (сайн засаглалын гүйцэтгэлийн үнэлгээний баг)-ээр гүйцэтгүүлнэ.

Төсөл Жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийг сургах, чадавхижуулах үйл ажиллагааг санхүүжилнэ. Тус дэд бүрэлдэхүүн хэсгийг SDC –ийн дэмжлэгээр хамтран санхүүжүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Төслийн удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээ

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) Сангийн яаманд байрлана. Гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг төслийн хэрэгжилтийн бүтцийг дэмжих бөгөөд , ажилчдын зардал, холбогдох зардал ба ХШҮ, худалдан авалт, санхүүгийн менежментийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг нь Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системийг боловсруулж хөгжүүлэх, төслийн суурь судалгаа, дунд хугацаа, үр дүнгийн төгсгөлийн үнэлгээг зохион байгуулах зэрэг ХШҮ-ний дэмжлэг үзүүлнэ.

Хэсэг Б. Бодлого ба хууль эрхзүйн шаардлага

Тус хавсралтад Монгол Улсад хэрэгжиж буй холбогдох бодлого, хууль эрх зүйн орчин, Дэлхийн банкны аюулгүй байдлыг хангах бодлогын шаардлагын талаар тусгасан болно.

Б.1 Газрын тухай хууль

Монгол Улсын Газрын тухай хуульд газар эзэмших гурван төрлийг заасан байдаг. Үүнд:

- Үнэгүй эзэмших: хот суурин газар хувийн орон сууц барих мөн хөдөө орон нутагт хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих
- Өмчлөл: хувь хүн, бүлэг этгээд, үйлдвэр аж ахуйн нэгж аль аль нь 15-60 жилийн хугацаатай хөдөө орон нутагт газар өмчлөх . Өмчлөх эрх нь бусдад эзэмшүүлэх, ашиглуулах, өвлүүлэх эсхүл зарж болно.

- Ашиглах эрх: Дээд хугацаа 5 жил. Ашиглах эрх өөр талд эзэмшүүлэх, ашиглуулах, өвлүүлэх, эсхүл зарж болохгүй бөгөөд улсаас газар чөлөөлөх тохиолдолд хэрэглэгчид нөхөн олговор өгөхгүй.

Хамгийн чухал нь Бэлчээрийн газар, хадлангийн талбай, ойн нөөц, нийтийн эзэмшилд зориулсан газар (тухайлбал усны хагалбар эсхүл давсны орд газар) болон засгийн газрын тусгай хэрэгцээний газарт эзэмшил болон өмчлөл өгдөггүй.

Гэсэн хэдий ч 2006 оны сүүлээр парламентад өргөн барьсан бэлчээрийн газар эзэмших гэрээ байгуулахыг дэмжсэн төслүүд байна.

Өнөөдрийн байдлаар хамгийн ихдээ 5 жилийн хугацаатай ашиглалтын гэрээг хэд хэдэн бүс нутагт туршилтын журмаар малчны бүлгүүдтэй хийгээд байна. (ТА-3 төслийн хэсэг биш хэдий ч)

Сумын засаг дарга болон багийн дарга нь газар ашиглах уламжлалт заншил, хамгааллын шаардлагууд, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны болон нөөц газруудын бэлчээрийн сэлгээний оновчтой хуваарь зэргийг харгалзан авч үзэж газар зохион байгуулалтын асуудлыг хариуцан ажилладаг.

Газрын тухай хууль нь байгалийн гамшиг эсхүл урьдчилан төлөвлөсөн малын шилжилт хөдөлгөөнийг шаардсан бусад онцгой байдлын үед өөрсдийн малчидад яаралтай тусламж үзүүлэх талаар хэлэлцээр хийхийг холбогдох засаг дарга нарт үүрэг болгосон байдаг.

Хэрэв эдгээр Засаг дарга нарын хооронд гэрээ байгуулж чадахгүй бол энэ асуудлыг дээд шатны засаг дарга эсхүл Засгийн газар шийдвэрлэнэ.

Газрын тухай хуульд улирлын чанартай бэлчээр, хадлангийн талбайг зохистой ашиглахыг дэмжих арга хэмжээ, журмыг зөрчсөн тохиолдолд торгуулийн арга хэмжээ авахаар заасан байдаг.

Сум дүүргийн засаг дарга нар баг, хорооны Хурлын саналд үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагад тариалангийн зориулалтын газрыг гаргаж өгч болно.

Газрын төлбөрийн тухай хууль болон Газар чөлөөлөх тухай хуульд Монгол Улсын газар зохион байгуулалттай холбоотой заалтууд орсон.

В.2 Орон нутгийн засаг захиргаа

Монгол Улсын нутгийн засаг захиргаа нь 21 аймаг, 330 сум, 1630 багаас бүрддэг бөгөөд орон нутгийн засаг захиргааны бүх түвшний төв нь Засаг дарга байдаг. Засаг дарга нар төрийг төлөөлөл болдог бөгөөд холбогдох дээд шатны засаг дарга нартаа шууд тайлагнадаг.

Аймаг, хотын засаг даргыг холбогдох хурал нэрийг нь дэвшүүлдэг бөгөөд Ерөнхий сайд батламжилна.

Засаг дарга, Засаг даргын орлогчоос гадна Засаг даргын тамгын газар дараахь хэлтэсүүдтэй. Төрийн захиргаа, Хууль, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт, Нийгмийн бодлого, Санхүү, төрийн сан, Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудит гэсэн хэлтэсүүдтэй. Түүнчлэн, засаг даргын харьяанд Байгаль орчин, аялал жуулчлал, Хүнс, ХАА, Мэргэжлийн хяналт гэсэн хэд хэдэн газар, агентлаг бий. Байгаль орчин аялал жуулчлалын

газар аймагт 10-15 хүнтэй, суманд байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч гэсэн орон тоотой.

Сумын ЗДТГ нь Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Нийгмийн ажилтан (боловсрол, эрүүл мэнд, халамж, соёл), Мал эмнэлэг үржлийн тасаг, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч, Нийгмийн халамжийн ажилтан (ядуурлыг бууруулах, ажлын байр, нийгмийн хамгаалал), Татварын ажилтан, Санхүүгийн хэлтэс (дарга, төрийн сангийн ажилтан, нягтлан бодогч), Газар зохион байгуулалтын мэргэжилтэн, Хуулийн болон дотоод ажлын мэргэжилтэн, Архивын ажилтан болон Багийн дарга нар гэсэн хамгийн дээд тал нь 20-30 хүний бүрэлдэхүүнтэй.

Орон нутгийн засаг захиргааны чиг үүргийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд зааж өгсөн байдаг. Мөн орон нутгийн удирдлагын чиг үүргийн талаархи 280 заалт бүхий 29 бусад хууль тогтоомж бий.

Аймаг, сумын засаг дарга нарт Засгийн газар, салбарын яам, агентлагуудаас олон тушаал, заавар, чиглэл, удирдамж авдаг. Гэхдээ эдгээр тушаал, заавруудыг хэрэгжүүлэхэд ихэнхдээ санхүүгийн болоод хүний нөөцийн чадавхи хязгаарлагдмал байна. Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд зохих үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд удирдлагын болон мэргэжлийн чадавхи дутмаг байдаг.

Б.3 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн тухай хуулиар Монгол Улсын нутгийн захиргааны байгуулал, чиг үүргийг зааж өгсөн. Баг, хороо, сум, аймгийн болон Улаанбаатар хотын түвшинд Иргэдийн хурал шийдвэр гаргана. Аймаг, нийгслэл, сум, дүүргийн Иргэдийн хурал жилд 2-оос багагүй удаа, баг хорооны хурал жилд хамгийн багадаа 3 удаа хуралдана. Иргэдийн хурлын товыг тэргүүлэгчид тогтоодог бөгөөд Хурлын дарга нь даргалдаг. Аймаг болон сумын түвшинд, засаг захиргааны бүс нутаг дахь хүн амын тооноос хамаарч хурлын төлөөлөгчдийн тоо 21-41 байна. Улаанбаатар хотын хувьд, Иргэдийн хурал 40 төлөөлөгчтэй.

Сум, аймаг нийслэлийн хурлын төлөөлөгчид дөрвөн жил тутамд болдог бүх нийтийн сонгуулиар сонгогдоно. 18 нас хүрсэн Монгол Улсын бүх иргэн баг хорооны нийтийн хуралд оролцох бөгөөд багийн 4 өрхийн нэг нь, сум, хорооны 20-30 өрхийн нэг нь хуралд оролцсон бол хурал хүчинтэйд тооцогдоно.

В.4 Нийгмийн халамжийн тухай хууль (2005)

Нийгмийн хамгаалал, халамжийн тухай хууль Монгол улсын иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрлийг зохицуулдаг бөгөөд нийгмийн хамгаалал, халамжийн удирдлагын тогтолцооны чиг үүрэг, бүтцийг тогтоож өгсөн байдаг.

Нийгмийн ажилтнуудыг сумын болон дэд бүсийн түвшинд дараахь үүрэгтэйгээр томилно:

- Эмзэг бүлгийн болон ядуу өрх, иргэдийн хэрэгцээ шаардлагыг үнэлэх,
- Нийгмийн хамгаалал, тэтгэмж авах өрх, иргэдийг олж тогтоох болон;
- Ядуу, нэн ядуу өрх, нийгмийн эмзэг бүлгийн чадавхийг сайжруулах чиглэлээр зөвлөх, сургах .

В.5 Үндэсний цөөнхийн талаархи бодлого

Үндэсний цөөнхийн эрх нь “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” (Монгол Улсын үндсэн хууль, 1992, 2-дугаар бүлэг 14 дүгээр зүйл) гэж заасан Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан байдаг.

Монгол Улсын Засгийн газар 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 255 тоот тогтоолоороо Цаатан иргэдийг дэмжих хөтөлбөрийг баталсан. Зөвхөн тайгад амьдарч буй цаатан иргэдийг дэмжих тус хөтөлбөрийн нийт санхүүжилт 624 сая төгрөг. Хөтөлбөрийн хүрээнд тэднийг сумын төвд амьдрахад нь зориулж 62 өрхөд монгол гэр, нарны зай олгосон бөгөөд тэднийг багийн хуралдаа оролцох боломжоор хангаж 12 сая төгрөгийн өртөгөөр 2 өрөөтэй Олон нийтийн байрыг барьж, малжуулах зорилгоор өрх бүрт 10 ямаа, цаа бугын үржлийг сайжруулах зорилгоор Оросын Тайгаас 20 цаа буга худалдан авч, 6 цаатан оюутанг их дээд сургуульд тэтгэлэгээр сургажээ. 2010 онд сумын ЗДТГ Цаатаны 2 отогт (баруун зүүн тайга) 2 эмч ажиллуулахаар төлөвлөж байв.

В.6 Уугуул иргэдийн талаарх Дэлхийн банкны Үйл ажиллагааны Бодлого (ВР/ОР 4.10)

Энэ бодлого нь хөгжлийн үйл явцыг уугуул иргэдийн нэр хүнд, хүний эрх, эдийн засаг, соёлын өвөрмөц байдлыг бүрэн хүндэтгэх замаар хэрэгжиж Банк-ны ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах эрхэм зорилгыг хангахад туслах зорилготой. Банкны санхүүжилтэнд хамрагдахаар төлөвлөж, уугуул иргэд-д нөлөө үзүүлэх бүх төслүүдийн хувьд Зээлдэгч орноос чөлөөт, урьдчилсан, мэдээлэл өгсөн хэлэлцүүлэг явуулахыг Банк шаарддаг. Энэ бодлогод “уугуул иргэд” гэж ерөнхийдөө дараахи онцлог чанаруудыг зохих хэмжээгээр хадгалсан өвөрмөц, эмзэг, нийгмийн ба соёлын бүлэг–үүд гэж авч үзсэн болно. Үүнд:

- (а) өөрсдийгөө өвөрмөц соёл бүхий уугуул бүлэг гэж тодорхойлж, тэднийг нийгмийн бусад бүлэг хүлээн зөвшөөрдөг;
- (б) төслийн газар нутагт газар зүйн өвөрмөц амьдрах орчинд эсвэл эртнээс уламжлагдан ирсэн газар нутагт өвөрмөц соёл зан заншил бүхий бүлэг хүмүүс амьдардаг ба тэд тухайн амьдрах орчин, газар нутаг-ийнхаа байгалийн нөөц баялагийг эзэмшдэг;
- (в) Нийгмийн зонхилох бүлэг, соёлоос ялгаатай уламжлалт соёлын, эдийн засгийн, нийгмийн, эсвэл улс төрийн бүтэцтэй;
- (г) тухайн улс, бүс нутгийн албан ёсны хэлнээс ялгаатай өөр нутгийн өвөрмөц хэлтэй байна.

Хэсэг С. Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих төлөвлөгөө

С.1 Танилцуулга

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих төлөвлөгөөг Дэлхийн банкны ОР 4.10, “Уугуул иргэд”-д заасны дагуу Монгол Улсын тогтвортой амьжиргаа(ТАЗ) -ын 3 дугаар үе шатны нэмэлт санхүүжилтэд зориулан боловсруулаад байна.

Төслийн хөгжлийн зорилго нь хөдөө орон нутагт нэн чухал ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал, иргэд, олон нийтийн оролцоог сайжруулахад оршино.

Нэгдсэн зохицуулалт, хяналт, шинжилгээ, үнэлгээ, санхүү, худалдан авалтын хяналтыг хадгалахын зэрэгцээ төслийн удирдлагын үүргийг орон нутгийн засаг захиргаа аймаг, сум (хөдөө) рүү аажмаар шилжүүлэх замаар удирдлагын төвлөрсөн бус тогтолцоог бий болгох зорилго бүхий төслийн нэгдсэн удирдлагаар дамжуулан Монгол улс даяар Үндэсний хэмжээнд 2019-2022 онд хэрэгжүүлэн энэ зорилгод хүрэх юм.

Тус хөтөлбөр нь ДБ-ны бодлогод тусгасан “Уугуул иргэд” гэсэн тодорхойлолтод нийцэх шинж чанар бүхий 2 бүлэгт нөлөөлж ажиллах юм. Нийгмийн үнэлгээ хийгдсэн бөгөөд үүнд чөлөөт, урьдчилан бэлтгэсэн мөн мэдээллээр хангах зөвлөлдөх уулзалтуудын үр дүнд төслийн зорилгыг олон нийт дэмжиж байгаагаар илэрхийлж, төслийн үйл ажиллагаанаас ашиг хүртэх сонирхолтой байгаагаар илэрхийлсэн болно.

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих төлөвлөгөөний хамгийн гол зорилго бол эдгээр бүлгүүд төсөлд оролцож, ашиг хүртэхийн тулд соёлын хувьд боломжтой байх нөхцлийг хангах явдал юм.

С.2 Монгол Улсын Үндэсний цөөнх иргэд

Монгол Улсад 30 гаруй ястан бий. Эдгээр бүх бүлгүүд нь Монголын нүүдэлчин овгуудын удам эсхүл цаг хугацааны явцад монголжсон Түрэг угсааны бүлгүүд юм. Халхууд хүн амын олонхийг буюу 84,5 %, казах 3,9%, дөрвөд 2,4%, Баяад 1.7%, Бурят 1,3% -ийг эзэлж байна.

Баруун Монголын нутагт амьдардаг казак цөөнхийн бүлгээс бусад бүх ястан халх хэлээр ярьдаг хүмүүстэй болон биетэйгээ ойлголцдог Монгол аялгаар ярьдаг. Казакууд тусдаа төрөлх аман ба бичгийн хэл - казак хэлтэй үндэсний цөөнх юм. Монголын ихэнх цөөнх ястанууд Халхтай адил төстэй зан заншил, уламжлалтай байдаг.

Монгол орны баруун хэсэгт нутагладаг лалын шашин зонхилсон, хэлний хувьд ялгаатай Казак ард түмэн мөн хойд хэсгээр нутагтай, нүүдэлчин уламжлалтай цаа бугын аж ахуйтай Цаатан ард түмнийг эс тооцвол Монголын ястануудын бүлгийг эдийн засаг, нийгэм эсхүл хууль ёсоор чухалчлан авч үздэггүй, нөгөө талаас төсөлд оролцох боломжийг хязгаарласан тааламжгүй нөхцөл байна.

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих тус төлөвлөгөө зөвхөн Цаатан болон Казак иргэдэд хамааралтай. ТА-3 төслийн Нэмэлт санхүүжилт аливаа сөрөг нөлөөлөл бий болгоно гэж төслийн нөлөөлөлт өртөх боломжтой хүмүүс таамаглаагүй гэдгийг Нийгмийн үнэлгээний явцад зохион байгуулсан зөвлөлгөөнүүд харуулж байна. Гэхдээ Цаатан болон Казак иргэд төсөлд оролцох, ашиг хүртэх боломжоо хязгаарлаж болзошгүй нөхцөл байдал байсаар байна.

С.2.1 Цаатан ба ТА-3 төсөл

Цаатангууд Хөвсгөл аймгийн хойд хэсэгт Цагааннуур сумын сэрүүн бүсийн тайгад цаа бугаа өсгөж үржүүлэн амьдардаг уламжлалтай. Цаа бугаа ойн хаг, хөвдөөр хооллодог. Цаатанууд цаа бугаа тээврийн хэрэгсэл болгон ашиглаж, сүүг нь хэрэглэж, арьсыг нь хувцас, орон байрандаа ашиглаж, хөгширсөн уналга ачилга, сүү саалинд ашиглахгүй цаа бугаа хүнсэндээ хэрэглэж байна.

Цаатан ард түмэн цөөхүүлээ, уламжлалт амьжиргаа нь багасч, ядуурал ихтэй, газарзүйн болон эдийн засгийн байдал онцлог, цаа буга үржих чадвар буурсан, цаа бугын төрөх жин багассан болон эрүүл мэндийн бусад асуудлаас үүдэж онцгой эмзэг байна.

ТА-3 төслийг хэрэгжүүлэх үеэр төслийн багийн гишүүд¹ Орон нутгийн хөгжлийн сангийн болон ТА-3 төслийн үйл ажиллагааг танилцуулах, мэдлэг олгох, эрүүл мэнд боловсрол, амьжиргаатай холбоотой тэдний хэрэгцээний талаар хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах зорилгоор тайгад ажиллаж цаатан ард түмэнтэй уулзав.

Хөнгөлтэй үнээр зарагддаг эм хүрэлцээ муутай байдаг талаар өндөр настанууд дурьдаж байлаа. Цаатанууд цаа бугын өвчний эмчилгээ үйлчилгээ, үржлийг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар цааны тоо толгойг буурч байгаа байдлыг зогсоох мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн туслалцаа хэрэгтэй байгааг илэрхийлж байв. Сумтай холбогдох харилцаа холбооны байдал ч бас авч үзэх асуудал байсан.

Цаатан иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжүүлэх дэд төсөл гэж үзэж болох өдөр тутамдаа тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлох мэдлэг чадвар дутмаг учраас өөрсдийн хэрэгцээгээ илэрхийлэх чадваргүй байна.

Цагааннуур сумын нийт хүн ам 2019 онд 1995 байсан бөгөөд 901 нь төвийн багт, 1077 нь алслагдсан багт амьдардаг. Цаатанууд сумын төвийн оршин суугчдын 16.8%-ийг, алслагдсан багийн оршин суугчдын 34.7%-ийг эзэлж байна. 85 өрхийн (2013 онд 80) 335 цаатан иргэн Тайгын ойд цаа бугаа түшиглэсэн уламжлалт уулын амьдралын хэв маягаар амьдарч байна.

2017 оны тооллогоор 2159 цаа буга тоологджээ. Цаатанууд амьдран байгаа байршилаараа “баруун” “зүүн” отогт хуваагддаг.

2006 оны байдлаар Баруун болон зүүн тайгад 335 цаатан байсан байна. Сумын төвд болон нам дор газар амьдардаг бусад цаатан эсхүл цаатан угсаатнууд ерөнхийдөө халхуудтай ижил амьдарч байна.

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих тус төлөвлөгөөний заалтууд нь юуны түрүүнд баруун болон зүүн тайгын ойд амьдардаг алслагдсан цаатануудад хамааралтай.

Цаатануудтай хийсэн хэлэлцүүлгээс гарсан зарчмын асуудал бол алслагдсан бүс нутагт уламжлалт хэв маягаар амьдарч байгаа иргэд төслийн шийдвэр гаргах үйл явцад оролцож чаддаггүй, үүний улмаас тэдэнд ашиг хүртэх тэгш боломж олдохгүй байгаа явдал юм.

¹ 2019 оны 6 сар.

Түүнчлэн, алслагдсан бүс нутагт амьдарч байгаа цаатануудын шийдвэр гаргах үйл явц бусад Иргэдийн хурлаас өөр байна. Хэлэлцүүлэгт оролцсон цаатанууд өөрсдийн гаргасан санал нь чанар муутай учраас татгалзах вий, олон хүмүүст үр өгөөжөө өгөх сумын өргөн хүрээний тэргүүлэх чиглэлтэй нийцэхгүй байх вий гэж санаа зовж байгаагаа илэрхийлсэн.

Цаатануудад мал эмнэлэгийн үйлчилгээ, цаа буга үржүүлэх зэрэг онцгой анхаарал хандуулах хэрэгцээ байгааг хэлж байсан. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт авахад цаашид тулгаарах бэрхшээл:

Дэд төслийн санал цуглуулах: Улирлын хүчин зүйл, цаатан иргэдийн байршлын алслагдсан байдал зэргээс үүдэн санал асуулгаар төслийн санал авна гэдэг бол энэ нөхцөлд амьдралд нийцэхгүй, боломжгүй зүйл юм. Орон нутгийн хөгжлийн сангийн журмаар бол багийн дарга асуулгыг тарааж дөрөвдүгээр сарын сүүл гэхэд буцааж цуглуулж авах ёстой. Багийн дарга мотоциклоор (хэдийгээр сайн үзүүлэлттэй ч гэсэн) тайгад амьдарч байгаа цаатануудад өвөл хавар хүрч очино гэдэг амаргүй.

Багт нэн чухал ач холбогдолтой дэд төслийн жагсаалт гаргах: Цаатанууд цөөхөн учраас багийн хурлаар тэд өөрсдийн дэвшүүлсэн дэд төсөлдөө санал авах, дэмжүүлэх боломж хомс байна. Цаатануудын ахлагч хэлэхдээ *“Цаатан иргэд цаахн учраас бидний дэвшүүлсэн дэд төсөл багийн нийтийн хурал дээр санал авах үед хасагдчихдаг. Ихэнх нь тайгад амьдардаг хүмүүс биш болохоор бидний санал дэмжигдэнэ гэж бараг л байхгүй. Бидний саналыг тэд угаасаа дэмжихгүй нь тодорхой. Ийм нөхцөл байдал биднийг багийн хуралд оролцохгүй байх нөхцлийг бүрдүүлдэг”* гэлээ.

Цаатан иргэдийн чадавх сул: Цаатан иргэд сумын засаг захиргаандаа хэрэгцээ, тулгамдаж байгаа асуудал, саналын хувилбараа боловсруулан эрэмбэлэж, өргөн барьж танилцуулж, харилцах чадваргүй байна.

Цаатан иргэдийн чадавхыг дээшлүүлэхийн тулд олон нийтийн оролцооны өөр өөр арга хэрэгсэл ашиглах чадвар, туршлага, мэдлэгтэй зөвлөх мэргэжилтэнтэй хамтран нарийвчилсан төлөвлөгөө гаргах шаардлагатай байна.

Энэхүү зохицуулалт нь иргэд хэрэгцээгээ илүү өргөн хүрээтэй харж, өөрсдийн санаа бодлоо орон нутгийн засаг захиргаандаа илүү үр дүнтэй байдлаар дэвшүүлж гаргаж ирэх боломжийг олгоно. Үүний үр дүнд орон нутгийн засаг захиргаа эдгээр хүмүүсийн хэрэгцээ, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр тэдэнд туслах арга замуудыг олж харах боломж бий болно.

Дүгнэж хэлэхэд, төсөл Цаатан иргэд орон нутгийн хөгжлийн сангаас ашиг хүртэх нөхцөл боломжийг бий болгохын зэрэгцээ тэднийг өөрсдийн сонголтоо ойлгуулах боломж нөхцлөөр хангах тусгайлсан арга хэмжээ бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэн, оролцоог нь нэмэгдүүлэн ажиллах хэрэгтэй байгааг Цаатан иргэдтэй хийсэн хэлэлцүүлэгүүд харуулж байв.

С.2.2 Казах ба ТА-3 төсөл

Монгол Улсын хүн амын 3.9% -ийг эзэлж буй Казахууд нь хамгийн том Үндэсний цөөнх юм. Өөр хэл, лалын шашны итгэл үнэмшил нь Казак болон Монгол бусад ястануудын хоорондох үндэстний ялгаатай байдлыг харуулж байгаа боловч Казах иргэдийн амьжиргаа эдгээр Монгол ястануудаас төдийлөн ялгарахгүй.

Орон нутгийн статистик мэдээллээр (Баян-Өлгий аймаг ,2012) Казак иргэд Баян-Өлгий аймагт ойролцоогоор 75.6% , Ховд аймагт 8.9% , Дархан-Уул аймагт 2.4% , Төв аймагт 0.9%, Орхон аймагт 0.6%, Хэнтий аймагт 0.5% нь амьдарч байна. Казак иргэдийн төлөвлөрөл өөр газар төдийлөн байхгүй учраас Үндэсний цөөнх иргэдийн оролцоог хангах/дэмжих тус хөтөлбөр эдгээр хоёр аймагт хамааралтай.

Баян-Өлгий, Ховд аймагт амьдардаг ихэнх казакууд төслийн үйл ажиллагаанд оролцох хэмжээнд мэргэжилийн түвшинд Монгол хэлээр ярьж, уншиж чаддаггүй. Казак иргэдийг Орон нутгийн хөгжлийн сангийн тухай зохих мэдээллээр хангах, үүний үйл явцад оролцуулах, сумын тамгын газрын мэргэжилтэнүүдэд, казах иргэдэд ТА-3 төслийн жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн талаархи мэдээллийг Монгол, Казак хэлээр бичгээр болон амаар сурталчилан түгээх , ойлголтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

С.2.4 Цаатан иргэдийн оролцоог хангах арга хэмжээг төлөвлөх

12. ТА-3 төслийн Нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгон зохион байгуулсан хэлэлцүүлэг болон ТХН-ийн 2019 онд хийсэн томилолтын үнэлгээнээс гарч ирсэн саналуудад хариу болгож уламжлалт Цаатан амьдрал ахуйтай иргэд төслийн үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцож төслөөс ашиг хүртэх нөхцлийг бүрдүүлэх дараахь онцлог шинж чанаруудыг төслийн загварт тусгасан. Авч хэрэгжүүлэх арга хэмжээнд:

Арга хэмжээ 1: Олон нийтийн дэмжлэг, хяналт үнэлгээнд Цаатан иргэдийн төлөөллийн оролцоог бий болгох

Алс бөглүү нутагт цаа маллан амьдарч байгаа Цаатан иргэд сумын төвд болж байгаа үйл ажиллагаанд ерөнхийдөө оролцож чаддаггүй бөгөөд орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад ч мөн оролцож чаддаггүй. Сумын түвшинд шийдвэр гаргах үйл явцад оролцож байгаа иргэд нь алслагдсан Цаатан иргэдтэйгээ холбоо харилцаа тогтоох нь бага, тэдний хэрэгцээ, сонголтын талаар бага мэддэг. Түүнчлэн сумын (хурлын) хуралдаанд иргэдийн дийлэнх олонхийн ашиг сонирхол л төлөөлөл болно гэсэн ойлголт байна.

2012 оны 11 дүгээр сарын 22 нд батлагдсан Сангийн сайдын 144 дүгээр тогтоолын Хавсралт 1-ийн 12.2 , “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам “-д аймаг болон дүүргийн орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл үйл ажиллагааны төлөвлөлт олон нийтийн оролцоог хангаж ажиллах гэж заасан.

Аймгийн дэмжих баг Цаатан иргэд, Орон нутгийн хөгжлийн сан, Багийн хурлын гүүр болон ажиллаж Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл боловсруулахад нь туслана. Цагааннуур суманд, ялангуяа алслагдсан багийн нутагт хэрэгжүүлсэн дэд төслүүдийн чанарыг хангахын тулд олон нийтийн хяналт, үнэлгээгээр дамжуулан дэд төслийн чанарт хяналт тавих боломжийг цаатануудад олгон Цаатанууд өөрсдийн санаа бодлоо илэрхийлэн чанартай хөрөнгө оруулалтыг шаардах боломжтой болно.

Арга хэмжээ 2: Орон нутгийн хөгжлийн санд санал гаргах өөр арга

ТА-3 төслийн аймгийн дэмжих баг сумын түвшинд багийн хурлуудын төлөөлөл илүү өндөр байх нөхцлийг бий болгож ажиллана. Цаатан идэвхжүүлэгч нар багийн хуралд Цаатануудыг

оролцуулах, тэдний өөрсдийн төслийн санал болон бусад төсөл саналд саналөө өгөхөд нь гол үүрэг гүйцэтгэн ажиллана.

Түүнчлэн тэдний Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт авахад өрсөлдөхүйц төсөл боловсруулах, шаардлага хангах чадвар хязгаарлагдмал байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Цаатан идэвхжүүлэгчийн тусламжтайгаар Баруун, Зүүн тайгын отогын Цаатанууд шийдвэр гаргадаг өөрсдийн уламжлалаараа төслийн саналаа боловсруулж, багийн хуралд бусад саналуудын хамт өөрсдийн саналаа дэвшүүлнэ.

Арга хэмжээ 3: Орон нутгийн хөгжлийн сангийн журам 2019 онд шинэчлэгдэж дэд төслийн санал авахдаа Фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар тусгасан. ТХН, Хөвсгөл аймгийн дэмжих баг хязгаарлагсан нутагт байгаа Цаатан иргэдийн дунд Фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулна.

Арга хэмжээ 4: Цаатан иргэдээс гаргасан дэд төслийг багийн түвшинд хэлэлцүүлэх, дэмжих нөхцлийг бүрдүүлэх боломжтой хувилбаруудыг олж тогтоох

С.2.5 Казак иргэдийн оролцоог хангах арга хэмжээг төлөвлөх

ТА-3 төсөл шийдвэр гаргахад Казак иргэдийн төлөөлөлийг тэгш хангах төлөвлөлтийн арга хэмжээг тусган Баян-Өлгий, Ховд, Дархан-Уул, Орхон аймагт Казак болон Монгол хэл дээр баримт бичиг мэдээлэл авах боломж нөхцлийг хангаж ажиллана. Тухайлбал:

Арга хэмжээ 1: Баян-Өлгий, Ховд аймагт олон нийтийн бүлгийн ахлагч, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын хэсгийн гишүүдийн оролцоо. Нутгийн хүн амын бага хувийг эзэлж байгаа Сэлэнгэ (0.5%), Төв (0.9%), Дорноговь, Увс болон Говьсүмбэр (0.2%) аймгуудад байгаа Казак иргэдэд төсөл хэрэгжүүлэх гарын авлагын хураангуй, сургалтын материал модуль, жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, бусад холбогдох мэдээллийг Казак хэл дээр бэлтгэж хүргэнэ. Харин Казакууд хүн амын дийлэнх хувийг эзэлж байгаа газарт төслийн явцуудыг тэр дундаа багийн хурлуудыг Казак болон Монгол хэл дээр зохион байгуулна. Багийн хурлын үр дүнтэй харилцааг хангах зорилгоор шаардлагатай бол Казак хэлний орчуулагч ажиллуулна.

Арга хэмжээ 2: Жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ дунджаас дээгүүр үнэлэгдсэн бусад аймаг, сумаас туршлага судлах, суралцах боломжийг олгох замаар Баян-Өлгий аймгийн аймгийн дэмжих багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

D. Гомдол барагдуулах механизм (GRM)

Гомдол барагдуулах механизм нь нөлөөлөлд өртсөн хүний асуудалд чиглэх бөгөөд жендерийн мэдрэмжтэй, соёлын хувьд тохирох, өртсөн хүмүүсээс үнэ өртөг шаардахгүй ойлгомжтой ил тод үйл явцыг ашиглан асуудлыг шуурхай шийдвэрлэнэ. ТА-3 төслийн нэгжийн олон нийттэй харилцах зөвлөх Хөвсгөл, Баян-Өлгийн аймгийн ОНТА-нарын хамтран ажиллах замаар үндэсний цөөнх иргэдээс ирсэн өргөдөл барагдуулах ажлыг зохион байгуулна. Нөлөөлөлд өртсөн хүн\олон нийтээс гаргасан гомдлыг эхлээд ТХН-ийн олон нийттэй харилцах асуудал хариуцсан зөвлөхөд өргөн барих ба гомдлыг дараах сувгуудаар мэдээлж болно:

Утас: 70009828

Е-шуудан: info@slp3.mn

Цахим хуудас: <http://tusuv-oronnutag.mof.gov.mn>

Фэйсбүүк: [facebook.com@LDFMongolia](https://www.facebook.com/LDFMongolia)

Твиттэр: <https://twitter.com/MongoliaSlp3>

Захиа явуулах хаяг: Тогтвортой амьжиргаа -3 төслийн нэгж, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Анкарагийн гудамж -23, Тод тавэр, 8-р давхар.

Аймаг бүрд байдаг төслийн орон нутаг дахь ажилтантай шууд уулзаж болно.

Е. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба төсвийн нөөц

№.	Оролоцогч	Арга хэмжээ	Хүлээх үүрэг	Төсөв (Ам.дол)
1.	ТА-3 ТХН	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none">- Сумдад ажиллах- ҮЦ-ийн оролцоог хангахад чиглэгдсэн төрөл бүрийн сургалт зохион байгуулах- Жил бүр энэхүү төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж байгаа тайланг ДБ хүргүүлэх	20.000
2.	Баян-Өлгий аймгийн АЧББ/ОНТА	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих	<ul style="list-style-type: none">- Аймгийн хөгжлийн бодлогтой энэхүү төлөвлөгөөг нийцүүлэх- Жилд нэг удаа алслагдсан иргэдэд төрийн 1 цонхны үйлчилгээ үзүүлэх- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн сургалтыг ТА-3 ТХН хамтран хэрэгжүүлэх	20.000
3.	Хөвсгөл аймгийн АЧББ/ОНТА	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих	<ul style="list-style-type: none">- Цаатан иргэдэд чиглэгдсэн жилийн төлөвлөгөөг боловсруулж ТА-3 ТХН хүргүүлэх- Сумын Тамгын газартай уялдаа хамтын ажиллагааг сайжруулах- Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн тайланг ТА-3 ТХН хүргүүлэх	30,000
	НИЙТ			70,000

Ж. Мэдээлэл ил болгох

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог хангах төлөвлөгөөний талаархи мэдээллийг улсын хэмжээнд уламжлалт Монгол хэл, Англи хэлээр түгээхээс Казак хэл дээр орчуулж олон нийтэд хүргэсэн болно. Түүнчлэн, ҮЦИОХ төлөвлөгөөг 21 аймгийн төвийн иргэний танхим, нийтийн номын санд байршуулсан.

Хэсэг Е. Хэлэлцүүлэг уулзалт

ТА-3 төслийн БОМТ болон ҮЦИОХ төлөвлөгөөний төслийн баримт бичгийг олон талт оролцогч талуудыг хамруулсан хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн тухай мэдээллийг ТХН-ээс аймгийн удирдлагад урьдчилан хүргүүлсэн. Түүнчлэн, хэлэлцүүлэг зохион байгуулах талаарх мэдээллийг утсаар бас хүргэсэн. Хөвсгөл аймгийн ОНТА хэлэлцүүлгийн тухай мэдээллийг Цагааннуур сумын удирдлагад хүргэж ажиллаа.

Хэлэлцүүлэг төлөвлөсөн 1-р сар нь жилийн хамгийн хүйтэн үе тул орон нутгийн иргэдэд хэлэлцүүлэгт өргөнөөр ирж оролцоход бэрхшээл болдог. Тиймээс, ТХН-ийн зүгээс хэлэлцүүлгийг аймгий төвд зохион байгуулсан бөгөөд сум орон нутгаас ирж байгаа төлөөллийн унааны зардалд дэмжлэг үзүүлсэн. Бүх хэлэлцүүлэг Монгол хэл дээр зохион байгуулагдсан. Казак хэлний орчуулагч бас бэлдсэн.

Е.1 Хөвсгөл аймгийн Мөрөн хотод хийсэн хэлэлцүүлэг

Өдөр: 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр

Байршил: Хөвсгөл аймгийн Мөрөн хот, аймгийн ЗДТГ-ын хурлын заал.

Оролцогчид: Хэлэлцүүлэгт Мөрөн хот, Хатгал тосгон, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Цагааннуур сумдын ЗДТГ-ын ажилтан, орон нутгийн иргэдийг төлөөлсөн нийт 28 хүн оролцсон. Оролцогчдын нэрийн жагсаалтыг Хүснэгт Е2.4-д хавсаргав.

Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал ба дэвшүүлсэн асуудлууд:

Уулзалтын үеэр хийсэн дээрх танилцуулгуудтай холбогдуулан оролцогчид дараах санал гаргаж байсан. Үүнд:

Х.Ган-Очир, Хөвсгөл Аймгийн ЗДТГ-ын дарга

Уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдод талархал илэрхийлж, ТА-3 төслийн үр дүн, ололт, сургамжийн талаар дүгнэж, энэ төсөл цаашид үргэлжлэн хэрэгжвэл аймаг, суманд улам илүү их үр нөлөө үзүүлэх болно гэдгийг онцлон тэмдэглэсэн. Тэрээр олон нийтийн хэлэлцүүлэгт амжилт хүсээд, БОНХМТ-нд тодорхой санал тусгаж оруулахад хувь нэмэр оруулах, өөрсдийн амьдрал, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөллийг сайтар тодорхойлж нөлөөллийг бууруулах, арилгах талаар тодорхой үйл ажиллагааг санал болгохыг оролцогчдоос хүсэв.

Ц.Маралмаа, Хатгал тосгоны санхүү албаны дарга.

БОНХМТ болон ҮЦОДТ-д тусгасан асуудлуудтай санал нэг байна. Шаардлагатай асуудлууд тусгагдсан байна.

ОНХС ил тод байдаг өгөөжтэй сан. 2013 оноос олон төсөл хэрэгжүүлсэн. Өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн төлүүдээс БОНийгмийн сөрөг нөлөө гараагүй.

1.Иргэдээс санал аваад эрэмблээд дахиад багийн хурлаар хэлэлцүүлдэг. Гэхдээ багийн хуралд цөөн хүн ордог учир хөдөөний хүмүүсийн гаргасан саналыг үгүйсгэдэг. Иймд багийн хурлаар дахин хэлэлцүүлдэг нь буруу байна.

2.Багийн төвшинд саналаа гаргаад сумын ажлын хэсэг дээр эрэмблэдэг.

Хатгал тосгон аливаа сургалт сурталчилгаанаас хоцордог учир нь төслийн бүх асуудал Алаг-эрдэнэ сумаар дамжин явдаг. Төслийн тайлангууд Алаг-Эрдэнэ сумаар гардаг учир үнэлгээний хувьд Хатгал тосгоны үнэлгээ доошоо орчихдог.

3. Хог хаягдлын менежментийг сайжруулах асуудал Хатгал тосгон болон Хөвсгөл нуурын эрэг орчимд байгаль орчны тулгамдсан асуудал болоод байна.

Д.Ялалт, Цагааннуур сум ЗДТГ-ын дарга

Манай сумын 90 гаруй % нь ТХГ-т хамрагддаг учир ТА төслийн үйл ажиллагааг ТХГ-т хэрэгжүүлэхэд БО-ны талаас нь харж үзэж экологийн эмзэг газарт нөлөө үзүүлэх үйл ажиллагааг дэмжихгүй гэсэн заалтыг өөрчилж өгнө үү.

Зуны улиралд тайгаруу очиход их хэцүү байдаг учир сургалт сурталчилгаа хийхэд хэцүү. Өвөл 4 сар хүртэл цаатан эрчүүд нь оторт явж эмэгтэйчүүд нь үлдсэн байдаг учир санал авахад хүндрэлтэй. Иймд ОНХС хариуцсан мэргэжилтэн болон БОХУБ, төслийн ажилтан хамтран явж уулзалт хийх боломжийг тодорхой хугацаанд бүрдүүлж өгнө үү.

ОНХС-ийн үйл ажиллагаануудыг багаар хэлэлцүүлэхээр цаатан иргэдийн санал хойш тавигддаг. Иймд цаатан иргэдээс гарсан саналыг тусгайлан эрэмблэх журам байх боломжийг дэмжиж өгөөч.

Цаатан иргэдийг мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагаа их хэрэгтэй. Цаа бугын вакцинуулалтыг төслийн хүрээнд дэмжиж хийхэд анхаарч өгөөч. Цаабугаын тоо өсөх хандлагатай байна. Одоогоор 2600 гаруй цаатай болсон. ТА төслөөс цаабугыг эрүүлжүүлэх, цус сэлгэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ их үр дүнтэй болсон учир энэ арга хэмжээг үргэлжлүүлэн дэмжих хэрэгтэй байна.

Цаатан иргэдийн Тува хэлний сургалтын асуудал хэрэгтэй байна. Ном материалаар хангах.

Я.Эрдэнэжав, Цагааннуур сумын БОХУБ

БЭМТ-нд цаа бугын бэлчээрийн нөөцийг судлаж үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ их байна. Баруун Зүүн тайгад бэлчээрийн талхагдал ихсэх хандлагатай байгаа.

АЖ-аас үүсч байгаа хог хаягдал, бие засах газрын асуудалд анхаарах энэ чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх

Аялал жуулчлалын бүс нутагт ирж байгаа жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

Цаа бугын гол бэлчээр нутаг нь ТХГ-т орсон учир ТХГ-ын хамгаалалтын бүсүүдийн онцлогт нийцүүлэн цаатан иргэдийн нүүдэллэх боломжийг нэмэгдүүлэх талаар ТХГ-ын хамгаалалтын захиргаа, сум, баг хамтран хэлэлцэж төлөвлөн хэрэгжүүлэх

Хог хаягдлын цэгийн байршил болон тохижуулалтыг стандартын дагуу шинэчлэн сайжруулах. БОНХМТ болон ҮЦОДТ-д гол асуудлуудыг тусгасан байна.

Энхбаяр, Алаг-Эрдэнэ сум

Цаа бугыг зарж үзүүлбэр болгодогийг зогсоох, цаа бугыг үзүүлэх зорилгоор ашиглаж байгаа хүмүүс амьтны амьдрах нөхцлийг хангахгүй, зөвхөн бизнесийн ашиг олоход зориулж байгаад анхаарах.

Бямбасүрэн, Арбулаг, ЗДТГ-ын дарга

ОН-т аялал жуулчлал хөгжсөнөөр нутгийн иргэдэд орлого олох боломж нэмэгдэж байна. Иймд аялал жуулчлалд чухал ач холбогдолтой зам үер усанд идэгдэж эвдрэх, хүн машин явах боломжгүй болж байна. Иймд аялал жуулчлалын зам засах, ус хангамжийг сайжруулах зорилгоор худаг уст цэгийг засаж шинээр гаргах асуудлыг дэмжиж өгөөч.

Батдорж, Алаг-Эрдэнэ сум, ЗДТГ-ын дарга

ОНХС нь орон нутагт санхүүгийн боломж олгож байгаа ганц сан юм. Энэ сан нь ТА төслийн үр нөлөөг дээшлүүлдэг. ОНХС-аас дэмжиж санхүүжүүлсэн аливаа үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгаа. Иймд БОНХМТ ба ҮЦОДТ-ийг дэмжиж байна. Бид үүрэг хариуцлагаа биелүүлж ажиллахын төлөө байна.

Сүүлийн жилүүдэд сангийн хөрөнгө оруулалт багасч байгаа үүнд анхаарч нэмэгдүүлж өгөөч. Орон нутгийн ЗДТГ-ыг ОНХС-аас дэмжих шаардлага их байдаг. Энэ нь дүрэм журмаараа хоригдсон байдаг.

Сумын удирдлага, мэргэжилнүүд, Багийн ЗД, иргэд малчдыг чадавхижуулах сургалтыг их явуулмаар байна. ОНХС-ийн дэмжлэгээр хэрэгжүүлэх төсөл үйл ажиллагааг санаачлах, төслийн санал боловсруулах аргагүйн сургалтыг иргэдэд өгөх.

Баттулга, Хөвсгөл аймгийн ХХААГ -ын дарга

Сум дахь МЭҮТ-ийн нэр нь өөрчлөгдөөд ХААТасаг гэж нэртэй болсон. ХААТ нь Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, үржил, бүртгэл, хариуцсан мэргэжилтэн, Хүнс, ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан ус хангамж хариуцсан мэргэжилтэн гэсэн 3 орон тоотой бий болсон. Энэ ажилтан БЭМТ-өөг хариуцаж ажиллана. Иймд БОНХМТ-нд энэ албан тушаалаар нь нэрийг өөрчлөн оруулах хэрэгтэй.

Хөвсгөл аймгийн сумдад ХААТ-ийн энэ асуудал хариуцсан мэргэжилтэн одоогоор ажиллахгүй байна.

Мэргэжилтнүүдэд зориулсан чадавхижуулах сургалтыг хийхдээ тэр сурсан ажилтан иргэд малчиддаа сургалт зөвлөгөө өгөх чадвартай болтол нь сургах хэрэгтэй байна. Малчдад бэлчээрийн даац, нөөцийг тохируулах, талхагдалаас урьдчилан сэргийлэх аргагүйн талаар сургалт явуулдаг чадварыг тэр хүмүүст олгох шаардлагатай.

С.Ганбат, Цагааннуур сумын цаатан иргэн

УТХГ-ыг байгуулахдаа цаатан иргэдийн нутаг, амьдралын онцлогийн талаар нарийн судалгаа хийгээгүйгээс цаатан иргэд нүүдэллэх нутаг сэлгэхэд их хүндрэл учирч байна. Экологийн эмзэг газрууд болон ТХГ-ын хамгаалалтын бүс, горим дэглэмийн талаар цаатан иргэдэд мэдээлэл, танилцуулга муу хийж байна. Амьдралын уламжлал онцлогийг харгалзан үзэхгүйгээр хууль зөрчсөн гэж торгох, хориглох асуудал их гарч байна. Цаатан иргэд байгалиа сайн хамгаалж ирэсэн, байгальтайгаа зохицон амьдарч байна. Гэтэл Улаан Тайгын ДЦГ-ын Хамгаалалтын Захиргаа биднийг байгалиа сүйтгэж байна, хохирол учруулж байна гэж үздэг, хамгаалалттай газрын гүнрүү нүүдэллэн зусах, намаржих, буу авч явахыг зөвшөөрдөггүй ба хамтарч ажиллахгүй байна. Цаа өсч байгаагийн хэрээр нутаг бэлчээр сэлгэх тэлэх шаардлага их гарч байна. Үүнийг анхаарч дэмжиж өгөх хэрэгтэй байна.

Оролцогчдын гаргасан саналуудаас БОНХМТ болон ҮЦОДТ-өөнд хамааралтай асуудлуудыг доорхи байдлаар нэгтгэн гаргав. (Хүснэгт Е-2.1)

Хүснэгт Е-2.2. Мөрөн хотод болсон хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал

Хэлэлцүүлэг хийсэн огноо	Хэлэлцүүлгийг хаана хийсэн	Оролцогчид	Хэлэлцүүлэгт оролцсон талууд, төлөөлөгчдийн санал, дүгнэлт	ТА-3 төслийн Нэмэлт санхүүжилтийн төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн явцад эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар гаргасан санал
2020 оны 1 сарын 08	Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотод	Нийт 28 хүн Мөрөн хот, Хатгал тосгон, Цагааннуур, Алаг-Эрдэнэ, Арбулаг	<ul style="list-style-type: none"> ОНХС-аас дэмжиж санхүүжүүлсэн аливаа үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгаа. Иймд БОНХМТ ба ҮЦОДТ-ийг дэмжиж байна. 	<ul style="list-style-type: none"> Өмнөх үе шатанд хэрэгжүүлсэн БОНХМТ-г хэрэгжүүлж ажиллах боломжтой

	сумдын ЗДТГ, иргэд, цаатан иргэдийн төлөөлөл. Нэрсийг хавсаргав.		<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын бүс нутагт ирж байгаа жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг дэмжиж хэрэгжүүлэх • АЖ-аас үүсч байгаа хог хаягдал, бие засах газрын асуудалд анхаарах энэ чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх • Хог хаягдлын цэгийн байршил болон тохижуулалтыг стандартын дагуу шинэчлэн сайжруулах. • Хог хаягдлын менежментийг сайжруулах асуудал Хатгал тосгон болон Хөвсгөл нуурын эрэг орчимд байгаль орчны тулгамдсан асуудал болоод байна. 	<ul style="list-style-type: none"> • ТА төслийн хүрээнд ОНХС-аас аялал жуулчлалын дэд бүтцийг дэмжихдээ хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг илүү дэмжих • Гол, нуур цөөрмийн ойролцоох хот сууринд хог хаягдлын менежментийг холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу явуулж байгаад тавих хяналтын сумдын БОХУБ хариуцан ажиллана • Усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгааллалтын бүсэд төслийн аливаа үйл ажиллагаа явуулахыг дэмжихгүй
			<ul style="list-style-type: none"> • БЭМТ-нд цаа бугын бэлчээрийн нөөцийг судлаж үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ их байна. • Цаа өсч байгаагийн хэрээр нутаг бэлчээр сэлгэх тэлэх шаардлага их гарч байна. Баруун Зүүн тайгад бэлчээрийн талхагдал ихсэх хандлагатай байгаа. 	<ul style="list-style-type: none"> • Сумын БЭМТ-нд цаабугын бэлчээрийн даац нөөцийг судлан менежментийг хэрхэн зохион байгуулах асуудлыг нэмж оруулах.
			<ul style="list-style-type: none"> • Сум дахь МЭҮТ-ийн нэр нь өөрчлөгдөөд Хөдөө Аж Ахуйн Тасаг (ХААТ) гэж нэртэй болсон. ХААТ нь Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, үржил, бүртгэл, хариуцсан мэргэжилтэн, Хүнс, ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан ус хангамж хариуцсан мэргэжилтэн гэсэн 3 орон тоотой бий болсон. 	<ul style="list-style-type: none"> • Иймд БОНХМТ-нд энэ албан тушаалаар нь нэрийг өөрчлөн оруулах хэрэгтэй. • ХААТ-ын Бэлчээр газар тариалан ус хангамж хариуцсан мэргэжилтэн төслийн хүрээнд хэрэгжүүлэх БЭМТ-өөг хариуцаж ажиллана.

			<ul style="list-style-type: none"> • Сумын удирдлага, мэргэжилнүүд, Багийн ЗД, иргэд малчдыг чадавхижуулах сургалтыг их явуулмаар байна. ОНХС-ийн дэмжлэгээр хэрэгжүүлэх төсөл үйл ажиллагааг санаачлах, төслийн санал боловсруулах аргазүйн сургалтыг иргэдэд өгөх. • Малчдад бэлчээрийн даац, нөөцийг тохируулах, талхагдалаас урьдчилан сэргийлэх аргазүйн талаар сургалт явуулах шаардлага их байна. 	<ul style="list-style-type: none"> • Мэргэжилтнүүдэд зориулсан чадавхижуулах сургалтыг хийхдээ тэр сурсан ажилтан иргэд малчиддаа сургалт зөвлөгөө өгөх чадвартай болтол нь сургах хэрэгтэй байна.
			<ul style="list-style-type: none"> • ОНХС-ийн үйл ажиллагаануудыг багаар хэлэлцүүлэхэд олонхийн саналаар цаатан иргэдийн санал хойш тавигддаг. Иймд цаатан иргэдээс гарсан саналыг тусгайлан эрэмблэх журам байх боломжийг дэмжиж өгөөч. 	<ul style="list-style-type: none"> • Үндэстний цөөнхийн эрх ашигт хамааралтай үйл ажиллагааг дэмжих журам нэмж оруулах асуудлыг судлан хэрэгжүүлэх

Хүснэгт Хөвсгөл аймгийн Мөрөн хотод хийсэн хэлэлцүүлэгт оролцогчдын нэр

№	Нэр	Сумын нэр	Албан тушаал	Утас
1	Х.Ган-Очир	Хөвсгөл Аймаг	ЗДТГ-ын дарга	
2	Ч.Батдорж	Хөвсгөл Аймаг	ТА-3 зохицуулагч	
3	Г.Баттулга	Хөвсгөл Аймаг	ХХААГ-ын дарга	
4	Б.Нарантуяа	Хөвсгөл Аймаг	ХХААГ, мэргэжилтэн	
5	Б.Догсомжав	Хөвсгөл Аймаг	БОАЖГ, мэргэжилтэн	
6	Б.Ариунсумъяа	Хөвсгөл Аймаг	ЗДТГ-ын мэргэжилтэн	
7	З.Батдорж	Алаг-Эрдэнэ	ЗДТГ-ын дарга	
8	Г.Түмэнбаяр	Алаг-Эрдэнэ	Бизнесмэн	
9	Ч.Хишигдэлгэр	Алаг-Эрдэнэ	БОХУБ	
10	Д.Майннэгэн	Алаг-Эрдэнэ	ЗДТГ-н НБ ажилтан	
11	Л.Энхбаяр	Алаг-Эрдэнэ	Багийн ИНХ-ын дарга	
12	Ц.Маралмаа	Хатгал	Тосгоны Ня-бо	
13	Б.Баярмаа	Арбулаг	Татварын байцаагч	
14	С.Аюушжав	Арбулаг	БАгийн ЗД	
15	Т.Цолмон-Эрдэнэ	Арбулаг	ЗДТГ-ын ажилтан	
16	Ц.Ганхуяг	Арбулаг	БОХУБ	
17	Л.Бямбасүрэн	Арбулаг	ЗДТГ-ын дарга	
18	П.Цэвээндулам	Арбулаг	Иргэн	
19	Б.Ичинхорлоо	Цагааннуур	ЗДТГ-ын ажилтан	
20	Я.Эрдэнэжав	Цагааннуур	БОХУБ	
21	Д.Ялалт	Цагааннуур	ЗДТГ-ын дарга	
22	С.Ганбат	Цагааннуур	Цаатан иргэн	

23	Б.Саяана	Цагааннуур	Цаатан иргэн	
24	Т.Ганбат	Цагааннуур	Цаатан иргэн	
25	Г.Өнөрсайхан	Цагааннуур	Цаатан иргэн	
26	Б.Ганбаатар	Хатгал	Захирагч	
27	С.Бат-Эрдэнэ	Цагааннуур	иргэн	
28	Н.Лхагвасүрэн	Цагааннуур	иргэн	

Е.2.2. Улаанбаатар хотод хийсэн хэлэлцүүлэг

Өдөр: 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр

Байршил: Улаанбаатар хот, “Корпрэйт энд Конвэншн” төвийн хурлын заал.

Оролцогчид: Хэлэлцүүлэгт Улаанбаатар хот дахь ТА-3 төслийн ТХН-ийн ажилтнууд, Баяг-Өлгий, Дундговь, Төв, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ажилтнууд, зарим сумдын захиргаа, орон нутгийн иргэдийг төлөөлсөн нийт 25 хүн оролцсон. Оролцогчдын нэрийн жагсаалтыг Хүснэгт Е2.4-д хавсаргав.

- **Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал ба дэвшүүлсэн асуудлууд:**

Уулзалтын үеэр хийсэн дээрх танилцуулгуудтай холбогдуулан оролцогчид дараах санал гаргаж байсан. Үүнд:

- Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн талаар

Сэлэнгэ аймгийн төлөөлөгчдийн санал.

- Хавар намрын хуурашилттай улиралд бэлчээр хадлангийн газарт түймэр гарч байгаль бэлчээрт хохирол учруулах
- Хүнсний ногоо тариалахад химийн бордоо, пестицидийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын горимын журам зөрсөнөөс сөрөг нөлөө үүсэх
- Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах асуудал байхгүйгээс хаягдлын хэмжээ нэмэгдэх
- Аялал жуулчлалын газар болон төв замын дагуу ариун цэврийн байгууламж байхгүйгээс бохирдол бий болох
- Хадлангийн талбайг их хэмжээтэй хашиж хамгаалах тохиолдолд зэрлэг амьтан нүүдэллэх боломж алдагдах
- Сумын төв суурин газруудад үерээс хамгаалах далан суваг байхгүйгээс газрын элэгдэл эвдрэл ихсэх

Баян-Өлгий аймгийн төлөөлөгчдийн санал

- Газар, бэлчээрийн талхагдлаас шалтгаалан хөрсний бохирдол бий болох
- Сумын төв суурин газрын хог хаягдлын цэг шаардлага хангахгүй байгаагаас агаарын болон хөрс усны бохирдол үүсч байна
- Бие засах газар арун цэврийн байгууламжууд шаардлага хангахгүй байгаагаас хөрсний болон ундны усны эх үүсвэр бохирдох
- Үерийн далан суваг шуудууны ашиглалтын үеийн журам зөрчигдөх, мониторинг муугаас газар эвдрэх нөхцөл байдал ихсэх
- Мал угаах банны ойролцоох газарт ургамалан бүрхэвч устаж хөрс талхлагдах

Дундговь аймгийн төлөөлөгчдийн санал

- ТА-3 төслийн нэмэлт санхүүжилтийн төслийг өмнөх үе шатны төслүүдтэй уялдуулж цогцолбор байдлаар хэрэгжүүлэн өмнө бий болгосон хүчин чадлын тогтвортой байдлыг сайжруулахад чиглүүлэх

- Иргэдэд төслийн талаар мэдээлэл сайн өгч зөв ойлголт бий болгох
- Малын ашиг шимийн нэмэгдүүлэх зорилгоор гаднаас шинэ үүлдэрийн мал, амьтан оруулж ирэхэд малын шинэ төрлийн өвчин, паразит нэмэгдэх магадлалтай
- ТА төслийн хүрээнд ОНХС-аас дэмжих төслүүдэд хог хаягдлыг ялган ангилах, дахин ашиглах шаардлага тавьдаг болох
- Булаг шандыг хашиж хамгаалах, ундрагыг сэргээх ажлыг нарийн зураг төсөлгүйгээр хийж байгаа нь тухайн булгийн ундаргыг ширгээх, сөрөг нөлөөлөх боломж бий болгож байна.
- Аймгийн болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг байгаль орчны үнэлгээ, Мониторингийн чиглэлээр дахин сургах шаардлагатай байна

Төв аймгийн төлөөлөгчдийн санал

- Малын бууц, барилгын хог хаягдлыг хаях цэгүүдийн байршлыг нарийн тогтоож, тохижуулах асуудал нэн шаардлагатай байна. Хог хаягдлын цэгийн байршил тодорхойгүй, буруу газар байрласнаас үүдэн хөрс, ус, агаарын бохирдол үүсгэдэг.
- Тухайн аймаг суманд байгаа соёлын өвийг сайн тодорхойлж зурагт тэмдэглээгүйгээс тэдгээрт сөрөг нөлөө учрах эрсдэл их байна.
- ТА төслийн хүрээнд ОНХС-аас санхүүжүүлж байгаа барилгын үйл ажиллагаанд хэрэглэж байгаа материалын чанар стандартад тавих шаардлага сул байгаагаас байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг.
- Шинээр хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаанууд өмнөх үе шатны үйл ажиллагаануудын үр нөлөө, үр дүнг тогтворжуулах, үргэлжлүүлэхэд хэр нөлөөлөх вэ? гэдгийг анхаарч үзэх.

Дундговь аймгийн төлөөлөгчдийн санал

- Малын үүлдэрийг сайжруулах сургалтыг малчдад зориулан явуулах хэрэгтэй байна.
- Хогийн менежмент муу байгаагаас орчны блхирдол үүсэх
- Иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа сайн хийх
- ЗДТГ-ын ажилтнуудыг байгаль орчны болон нийгмийн нөлөөлийг үнэлэх аргачлалд сургах
- Сумын хэмжээний байгаль орчин, байгалийн нөөц, дэд бүтцийг зураглалд сайн тусгах
- Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар БОНХМТ болон ҮЦОДТ-г хэрэгжүүлэх зардал төсвийг аймаг сумдад тодорхой төлөвлөж өгөх хэрэгтэй
- АЧББ-т байгаль орчны зөвлөх мэргэжилтэн ажиллуулах

Сэлэнгэ аймгийн төлөөлөгчдийн санал

- АЧББ шиг үүрэгтэй багийг сум бүрт байгуулж ажиллуулах
- Энэ онд бүх сумын ИТХ шинээр сонгогдох учраас шинээр томилогдох Засаг дарга, Багийн ИНХ-ын дарга, Багийн засаг дарга нарыг сургалтанд хамруулж ТА төслийн талаар мэдээлэл ойлголт, аргазүйг нь сайжруулах шаардлагатай
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төслийн үйл ажиллагаанд хамруулах тал дээр анхаарч тэдний мэдлэг мэдээллийг сайжруулах
- ТА-3 төслийн хүрээнд байгаль орчин нийгмийн хамгааллын сайжруулах талаар хуримтлуулсан сайн туршлагыг дэлгэрүүлэх
- БОНБУ хийлгэхэд бүрдүүлэх шаардлагатай материалын жагсаалтыг хэвлэж олон нийтэд тараах
- ОНХС-аас санхүүжүүлэх үйл ажиллагааны санал гаргах, боловсруулах талаар иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт сурталчилгаа хийх

Баян-Өлгий аймгийн төлөөлөгчдийн санал

- Газар, хөрс, усны бохирдолын өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаа хийлгэх
- Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг иргэдийн дунд хийх

- Барилга барих зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмал (элс хайрга шавар, чулуу) авч ашигласан газрыг нөхөн сэргээх шаардлагыг ОНХС-аас хэрэгжүүлж буй бүх үйл ажиллагаанд тавьж мониторинг хийх
- Мах, арьс шир боловсруулах үйлдвэрээс гарах хог хаягдлыг дахин боловсруулах асуудал чухал байна.
- Сум бүрт байдаг Тогтвортой Хөгжлийн Хэсгийн гишүүдийг сургах
- Сумдын Багийн ИНХ-ын дарга, Багийн засаг дарга нарыг сургаж чадавхижуулах
- Игэдийг омгийн ахлагчаар дамжуулан мэдээлэлээр хангах
- ИТХ-ын төлөөлөгчдийг сургаж чадавхижуулах

Төв аймгийн төлөөлөгчдийн санал

- БОНХМТ болон ҮЦОДТ-ний талаар иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах
- Төслийн хүрээнд үүсч болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар иргэд олон нийтэд мэдээлэх
- ОНХС-ийн дэмжлэгтэй баригдах аливаа барилгын орчин тойрныг тохижуулах, цэцэрлэгжүүлэх шаардлага тавих
- Дэд төслүүд эхлэхийн өмнө болон дууссаны дараа байгаль орчны байдалд үнэгээ хийдэг болох
- Дэд төслийн цаашдын тогтвортой байдлын үнэлгээ хийдэг болох
- БЭМ төлөвлөгөө боловсруулахын өмнө бэлчээрийн нөөц даацын судалгаа хийх
- Дэд төслүүдийн хэрэгжилт үр нөлөөг иргэдэд тайлагнах
- Сумын БОХУБ-ыг БОНХМТ-ний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх чадвартай болгон сургах

Оролцогчдын гаргасан саналуудаас БОНХМТ болон ҮЦОДТ-өөнд хамааралтай асуудлуудыг доорхи байдлаар нэгтгэн гаргав. (Хүснэгт E-2.3)

Хүснэгт E2.3. Улаанбаатар хотод болсон хэлэлцүүлэгт оролцогчдын санал санал

Хэлэлцүүлэг хийсэн огноо	Хэлэлцүүлэг хийсэн газар	Оролцогчид	Хэлэлцүүлэгт оролцсон талууд, төлөөлөгчдийн санал, дүгнэлт	ТА-3 төслийн Нэмэлт санхүүжилтийн төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн явцад эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар гаргасан санал
2020 оны 1 сарын 15	Улаанбаатар хот, Корпорэйт энд	Нийт 25 хүн ТА-3 төслийн ТХН-ийн ажилтнууд,	<ul style="list-style-type: none"> • Хавар намрын хуурашилттай улиралд бэлчээр хадлангийн газарт түймэр гарч байгаль бэлчээрт хохирол учруулдаг 	<ul style="list-style-type: none"> • БЭМТ-нд бэлчээрийг түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээг тусгах

	<p>Баяг-Өлгий, Дундговь, Төв, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ажилтнууд, зарим сумдын захиргаа, орон нутгийн иргэдийг төлөөлөл. Нэрсийг хавсаргав.</p>	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын газар болон төв замын дагуу ариун цэврийн байгууламж байхгүйгээс бохирдол бий болох • Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах асуудал байхгүйгээс хаягдлын хэмжээ нэмэгдэх • Сумын төв суурин газрын хог хаягдлын цэг шаардлага хангахгүй байгаагаас агаарын болон хөрс усны бохирдол үүсч байна • Малын бууц, барилгын хог хаягдлыг хаях цэгүүдийн байршлыг нарийн тогтоож, тохижуулах асуудал нэн шаардлагатай байна. Хог хаягдлын цэгийн байршил тодорхойгүй, буруу газар байрласнаас үүдэн хөрс, ус, агаарын бохирдол үүсгэдэг. 	<ul style="list-style-type: none"> • ТА төслийн хүрээнд ОНХС-аас аялал жуулчлалын дэд бүтцийг дэмжихдээ хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг илүү дэмжих • Хог хаягдлын менежментийг холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу явуулж байгаад тавих хяналтыг сумдын БОХУБ хариуцан зохион байгуулах • ТА төслийн хүрээнд ОНХС-аас дэмжих төслүүдэд хог хаягдлыг ялган ангилах, дахин ашиглах шаардлага тавьдаг болох
		<ul style="list-style-type: none"> • Хадлангийн талбайг их хэмжээтэй хашиж хамгаалах тохиолдолд зэрлэг амьтан нүүдэллэх боломж алдагдах 	<ul style="list-style-type: none"> • Сумын БЭМТ-нд хадлангийн талбайн байршилыг тодорхой тусгаж хашилгүйгээр хамгаалах арга хэмжээг тусган зохион байгуулах асуудлыг нэмж оруулах.
		<ul style="list-style-type: none"> • Бие засах газар ариун цэврийн байгууламжууд шаардлага хангахгүй байгаагаас хөрсний болон ундны усны эх үүсвэр бохирдох 	<ul style="list-style-type: none"> • ОНХС-аас санхүүжүүлэх аливаа байгууламжуудын дэргэд бие засах газар ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах, цэвэрлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тусгаж хэрэгжүүлдэг байх.
		<ul style="list-style-type: none"> • Булаг шандыг хашиж хамгаалах, ундрагыг сэргээх ажлыг нарийн зураг төсөлгүйгээр хийж байгаа нь тухайн булгийн ундаргыг ширгээх, сөрөг нөлөөлөх боломж бий болгож байна. 	<ul style="list-style-type: none"> • Булаг шандыг хашиж хамгаалах, ундрагыг сэргээх үйл ажиллагаанд БОНБУ хийж ажлын зураг төсөл тооцоог тусгайлан хийдэг байх.

		<ul style="list-style-type: none"> • Аймгийн болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг байгаль орчны үнэлгээ, Мониторингийн чиглэлээр дахин сургах шаардлагатай байна • ЗДТГ-ын ажилтнуудыг байгаль орчны болон нийгмийн нөлөөлийг үнэлэх аргачлалд сургах • Энэ онд бүх сумын ИТХ шинээр сонгогдох учраас шинээр томилогдох Засаг дарга, Багийн ИНХ-ын дарга, Багийн засаг дарга нарыг сургалтанд хамруулж ТА төслийн талаар мэдээлэл ойлголт, аргазүйг нь сайжруулах шаардлагатай • ТА-3 төслийн хүрээнд байгаль орчин нийгмийн хамгааллын сайжруулах талаар хуримтлуулсан сайн туршлагыг дэлгэрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • БОНХМТ ба ҮЦОДТ-нд сургалтын хуваарь төлөвлөгөөг нэмж тусгах • Мэргэжилтнүүд, удирдлага, албан тушаалтнуудад зориулсан чадавхижуулах сургалтыг хийхдээ тэр сурсан ажилтан иргэд малчиддаа сургалт зөвлөгөө өгөх чадвартай болтол нь сургах хэрэгтэй байна.
--	--	--	---

Хүснэгт E2.4. Улаанбаатар хотод хийсэн хэлэлцүүлэгт оролцогчдын нэр

№	Нэр	Сумын нэр	Албан тушаал	Утас
1	М.Энхбат	Улаанбаатар	ТА-3,ТХН-ийн мэргэжилтэн	
2	Г.Одсүрэн	Улаанбаатар	ТА-3 ТХН-ийн мэргэжилтэн	
3	А.Мөнхбаяр	Улаанбаатар	ТА-3 ТХН-ийн мэргэжилтэн	
4	Б.Үржинханд	Дундговь аймаг	ЗДТГ, ҮХҮА-ны дарга	
5	С.Хулан	Дундговь аймаг	ЗДТГ, Нийгмийн бодлогын мэргэжилтэн	
6	Ж.Түмэндэлгэр	Дундговь аймаг	ИТХ-ын ахлах ажилтан	
7	Э.Уяанга	Дундговь аймаг	БОАЖГ-ын мэргэжилтэн	
8	Б.Энхтуяа	Дундговь аймаг	ТА-3 зохицуулагч	
9	Ж.Мөнхсаруул	Дундговь аймаг	ЗД-ын орлогч	
10	С.Эрдэнэцогт	Төв аймаг	БОАЖГ-ын мэргэжилтэн	
11	Б.Тунгалаг	Төв аймаг	ЗДТГ-ын мэргэжилтэн	
12	Г.Болдбаатар	Төв аймаг	Алтанбулаг сум, Баг ЗД	
13	Л.Эрдэнэбаатар	Төв аймаг	Эрдэнэ сум, Засаг дарга	
14	Н.Батмөнх	Төв аймаг	Алтанбулаг сум, ИТХ-ын дарга	
15	Ц.Отгонтулга	Сэлэнгэ аймаг	ЗДТГ-ын ажилтан	
16	Т.Пүрэвсүрэн	Сэлэнгэ аймаг	ИТХ-ын НБ дарга	
17	Н.Эрдэнэсүрэн	Сэлэнгэ аймаг	БОАЖГ-ын мэргэжилтэн	
18	Н.Захиралбаатар	Сэлэнгэ аймаг	Хушаат сум, ЗДТГ-ын дарга	
19	Б.Ганзориг	Сэлэнгэ аймаг	иргэн	
20	Э.Мөнх-Од	Сэлэнгэ аймаг	Баруунбүрэн сумын иргэн	
21	Д.Майра	Баян-Өлгий	ЗДТГ-ын НБ мэргэжилтэн	

22	Т.Ариунцэцэг	Баян-Өлгий	ЗДТГ-ын байгаль орчны мэргэжилтэн	
23	А.Сэрыкболат	Баян-Өлгий	ИТХ-ын НБ-ийн дарга	
24	А.Ерболат	Баян-Өлгий	ЗДТГ-ын мэргэжилтэн	
25	Г.Гансүх	Улаанбаатар	Үндэсний зөвлөх	

Мэдээллийг ил тод болгосон:

Энэхүү төлөвлөгөөг дараах байдлаар нээлттэй болгосон:

1. Бүх аймгийн Орон нутгийн төслийн ажилтан нарын өрөөнд 1 хувийг байрлуулсан.
2. Аймгийн төвүүдийн номын санд болон Иргэний танхимд 2020 оны 1 дүгээр сарын 28 өдөр байрлуулсан.
3. www.slp.mn. Вебсайтад тавьсан